

УЛСЫН ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕССЫН
БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ ТӨРЛӨӨР ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖИЛ

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Аудитын нэр, код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	4
Эрсдэлийн үнэлгээ	4
Аудитын арга зүй	4
Ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	5
Аудитын багийн бүрэлдэхүүн.....	5
Аудитын гүйцэтгэх хугацаа.....	6
Дүгнэлт, тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам ..	6
Шаардагдах хөрөнгө, нөөц	6

Хавсралт №1 Эрсдэлийн үнэлгээ

Хавсралт №2 Асуудлын шинжилгээ

Хавсралт №3 Арга зүй

Хавсралт №4 Аудитын хөтөлбөр

Хавсралт №5 Дүгнэлт гаргах концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил

Хавсралт №6 Концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжиж буй төслүүдийн зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах “Ажлын даалгавар”

Хавсралт №7 Концессын төслүүдийн зураг төсөл, төсөв, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд гаргасан шинжээчийн дүгнэлт, ажлын гүйцэтгэлийн тайлан бичих загвар

Хавсралт №8 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт

Хавсралт №9 Материаллаг байдлын тооцоолол

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР



ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Аудитын нэр:

"Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт"-д дүгнэлт гаргах.

2. Аудитын код:

ГАГ-2018-03-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2018 оны 03 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан "Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө"-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

4. Аудитын зорилт:

Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт "улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гаргах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах" гэж заасны дагуу төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад батлагдаж, концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад энэхүү аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Концессын зүйл нь холбогдох хууль, эрх зүйн шаардлагад нийцэж жагсаалтад зохих ёсоор тусгагдаж, концесс эзэмшигчийг хуулийн дагуу сонгон шалгаруулсан эсэх;
- Концессын төслүүдийн хэрэгжилт, түүнд тавих хяналт барилгын норм норматив, хууль тогтоомжийн дагуу хэрэгжиж нийгэмд үр өгөөж бий болсон эсэх.

5. Хамрах хүрээ:

Аудитад Хөвсгөл, Ховд аймагт концессын гэрээгээр хэрэгжсэн 4 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, холбогдох төрийн

төв, орон нутгийн захиргааны байгууллага, зураг, төсвийг зохиогч, магадлал хийсэн хуулийн этгээд, концесс эзэмшигчид, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч төрийн байгууллага, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан төсөл, арга хэмжээний үйл ажиллагааны тайлан, концессын зүйлийн төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой ажлын баримт материал, ажлын гүйцэтгэл зэрэг баримтат нотлох зүйлсийн хүрээнд гүйцэтгэнэ.

6. Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нийт 242 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 2017 оны байдлаар нийт 57 зүйлийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан байна. Үүнээс нийт 42 гэрээ нь концессын “барих-шилжүүлэх” төрлөөр байгуулагдан хэрэгжиж байна.

Үндэсний аудитын газраас 2017 он, 2018 оны эхний хагас жилд нийт 15 төслийн хэрэгжилтэд дүгнэлт гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

2018 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар дээрх концессын “барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулагдсан төслүүдээс 4 төсөл хэрэгжиж дууссан байна. Үүнд:

1. Жагсаалтын 46.21-д Засгийн газрын 2016 оны 73 дугаар тогтоолоор нэмэгдэж батлагдсан Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 150 ортой цэцэрлэгийн барилгыг барих, шилжүүлэх гүйцэтгэгчийг уралдаант шалгаруулалтын аргаар сонгох төсөл;
2. Жагсаалтын 46.24-д Засгийн газрын 2016 оны 73 дугаар тогтоолоор нэмэгдэж батлагдсан Ховд аймгийн Жаргалант суманд 180 ортой, 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих, шилжүүлэх гүйцэтгэгчийг уралдаант шалгаруулалтын аргаар сонгох төсөл;
3. Жагсаалтын 46.34-д Засгийн газрын 2016 оны 73 дугаар тогтоолоор нэмэгдэж батлагдсан Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 320 суудалтай сургуулийн барилга барих, шилжүүлэх гүйцэтгэгчийг уралдаант шалгаруулалтын аргаар сонгох төсөл;
4. Жагсаалтын 46.47-д Засгийн газрын 2016 оны 74 дүгээр тогтоолоор нэмэгдэж батлагдсан Хөвсгөл аймгийн Тариалан суманд 500 хүний суудалтай соёл, спортын цогцолбор барилга барих, шилжүүлэх гүйцэтгэгчийг уралдаант шалгаруулалтын аргаар сонгох төсөл.

7. Эрсдэлийн үнэлгээ:

Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлэв. (Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-д үзүүлэв.)

8. Аудитын арга зүй:

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан концессын асуудал хариуцсан болон холбогдох төрийн захиргааны байгууллага, захиалагч, хэрэгжүүлэгч байгууллагуудын асуудал хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, төсөл, арга хэмжээний гэрээ, батлагдсан зураг төсөв, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, ажлын гүйцэтгэлүүд зэрэг төлөвлөлт, хэрэгжилтийн холбогдох бусад шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ,

чанарын хяналтыг Газрын захирал, аудитын менежер хийж, аудиторрууд хэрэгжсэн ажлын үр дүнг дүгнэлтэд нэгтгэнэ.

11. Аудитын гүйцэтгэх хугацаа:

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 06 дугаар сарын 22-ноос эхлүүлж 2018 оны 7 дугаар сарын 17-ны дотор Монгол Улсын Ерөнхий аудиторроор батлуулна.

Аудитын талбарын ажлыг 2018 оны 8 дугаар сарын 06-аас 31-ний өдрийг хүртэлх хугацаанд, тайлагналын үе шатны ажлыг 8 дугаар сарын 31-ээс 9 дүгээр сарын 07-ны өдрийн хооронд гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг хийлгэн Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталгаажуулан 2018 оны 10 дугаар сарын 1-ний дотор УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн байна. (Аудитын хөтөлбөрийг хавсралт №4-т үзүүлэв)

Гэрээгээр хамтран ажиллах этгээд нь Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээ болон түүний салшгүй хэсэг болох "Ажлын даалгавар"-т тусгагдсан нөхцөл, шаардлага, заасан хугацааны дагуу дүгнэлт, тайланг бэлтгэж, гэрээнд заасан хугацаанд ирүүлнэ.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Одгэрэл Үндэсний аудитын газраас орон нутагт томилолтоор ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах чиглэл, хуваарийг хянан баталгаажуулна.

12. Дүгнэлт, тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Дүгнэлт тайлан нь үндсэн мэдээлэл, концессын зүйлийн товч танилцуулга, дүн, дүгнэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал гэсэн агуулгаар үндсэн зорилтын хүрээнд өмнөх тайлагнал (ҮАГ-ГАГ/2017/06.01-ДГА)-ын загварын дагуу бичигдэнэ.

Төсөл, арга хэмжээний дүгнэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 17-нд Аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 2018 оны 9 дүгээр сарын 20-нд чанарын баталгаажуулалт хийлгэнэ.

13. Шаардагдах хөрөнгө, нөөц:

Аудитад шаардагдах зардлын төсөв, түүний тооцоолол. Үүнд:

А.Боловсон хүчин: ҮАГ-аас 2 хүн х 55 хүн/өдөр = 110 хүн/өдөр
Газрын захирал, аудитын менежерийн хяналт 30 хүн/өдөр

Б.Санхүүгийн нөөц: Нийт 50,668.3 мянган төгрөг

а/ Цалин

- Цалин 2 хүн * 56.6¹ мянган төгрөг * 55 өдөр = 6,226.0 мянган төгрөг
- Цалин 2 хүн * 80.2² мянган төгрөг * 15 өдөр = 2,406.0 мянган төгрөг

б/ Бичиг хэрэг 500.0 мянган төгрөг

¹ Аудиторуудын 1 өдрийн дундаж цалингаар тооцоолов

² Газрын захирал, аудитын менежерийн 1 өдрийн дундаж цалингаар тооцоолов

г/ Дотоод томилолт, зам хоног: 4 хүн 5-7 хоног 3,536.3³ мянган төгрөг

д/ Хөндлөнгийн шинжээч, экспертийн зардалд
1 объект дунджаар 9,500.0* 4=38,000,0 мянган төгрөг

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, диктафон, зургийн аппарат,
бусад техник хэрэгсэл.

Дүгнэлт гаргах ажлын төлөвлөгөөг

Хянаж зөвшөөрсөн:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

Боловсруулсан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Софон
2018.07.17

Л.ОДГЭРЭЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Цолмон

Б.САРУУЛ

АУДИТОР

У.Цолмон

Ц.ЦОЛМОН

2018 оны 07 дугаар сарын 17

³ Дэлгэрэнгүйг орон нутагт томилолтоор ажиллуулах тушаалын хавсралтаарх төсөөт тусгасан

АУДИТЫН ЕРӨНХИЙ ЭРСДЭЛҮҮД БА ҮНЭЛГЭЭ

Хавсралт №1

№	Эрсдэл	Магадлал	Үр дагавар	Үнэлгээ
1.Концессын зүйл нь холбогдох хууль, эрх зүйн шаардлагад нийцэж, жагсаалтад зохих ёсоор тусгагдсан байна уу?				
1	Концессын зүйлийн хэрэгцээ шаардлага, хүчин чадлыг оновчтой тодорхойлоогүй байх	бага	дунд	дунд
2	Концессын зүйлийн байршил оновчтой тогтоогдоогүй байх	бага	их	дунд
3	Концессын зүйлийг хэрэгжүүлэхээс өмнөх бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй байх	их	их	их
4	Концессын зүйлийн жагсаалтад тусгах арга хэмжээний зардал, ашгийн тооцоо судалгаа хийгдээгүй байх	их	их	их
5	Концессын зүйлийг ач холбогдлоор нь эрэмбэлээгүй байх	их	дунд	дунд
6	Засгийн газар концессын зүйлийн жагсаалтыг батлахдаа хуульд нийцүүлэн батлаагүй байх	их	дунд	дунд
2.Концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдсан уу?				
1	Уралдаант шалгаруулалт явуулах бэлтгэл ажил бүрэн хангагдаагүй байх	бага	дунд	дунд
2	Сонгон шалгаруулалтыг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байх	бага	их	дунд
3	Концессын зүйлийн зориулалтыг өөрчилж уралдаант шалгаруулалтыг зохион байгуулсан байх	бага	их	дунд
4	Гүйцэтгэгчийг оновчтой сонгож чадаагүй байх	бага	их	дунд
5	Захиалагчийн хяналт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдтэй шууд гэрээ байгуулсан байх	дунд	их	дунд
6	Шууд гэрээ байгуулах нөхцөл бүрдээгүй байхад шууд гэрээ байгуулсан байх	дунд	их	дунд
7	Жишиг баримт бичгийг зохих шаардлагын дагуу боловсруулаагүй, архивын нэгж болгон хадгалаагүй байх	дунд	их	дунд
8	Концессын гэрээний дүн нь төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхэд зарцуулсан өртгөөс дутуугүй байх.	дунд	их	дунд
3.Концессын төслүүдийн зураг төсөл, төсөв болон барилга угсралтын ажил холбогдох хууль тогтоомж, норм норматив, хэм хэмжээний дагуу хийгдэж зохиогч, захиалагчийн хяналт үр нөлөөтэй хэрэгжсэн үү?				
1	Концессын зүйлийн төсөвт өртгийг бодитой тооцоогүй байх	дунд	их	дунд
2	Концесс эзэмшигч төсөл, арга хэмжээний биелэлтийн явц, гүйцэтгэлийг үнэн зөв гаргаж, тайлагнаагүй байх	их	их	их
3	Концессын зүйлийн хэрэгжилтэд тавьсан хяналтын тайланг тогтсон хугацаанд ирүүлээгүй байх	их	их	их

Хавсралт №1				
4	Захиалагчийн хяналтыг давхардуулан хэрэгжүүлсэн байх	дунд	ИХ	ДУНД
5	Захиалагчийн хяналтын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжээгүй байх	ИХ	ИХ	ИХ
6	Захиалагчийн үйл ажиллагаанд дотоодын хяналтгүй байх	ИХ	ИХ	ИХ
7	Захиалагчийн хяналт тавих байгууллагаас чанаргүй гүйцэтгэсэн ажлыг засах чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг концесс эзэмшигч хэрэгжүүлээгүй байх	дунд	ИХ	ДУНД
8	Санхүүжилтийг захиалагчийн хяналттай уялдуулан олгоогүй байх	дунд	ИХ	ДУНД
9	Гэрээ дүгнээгүй, гэрээний хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аваагүй байх	ИХ	ИХ	ИХ
10	Барилгын аюулгүй байдал, чанарт концесс эзэмшигчээр гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй, тоног төхөөрөмжид туршилт хийсэн акт үйлдэгдээгүй байхад ашиглалтад оруулсан байх	ИХ	ИХ	ИХ
4.Концессын зүйлийг хэрэгжүүлснээр нийгэмд үр өгөөж бий болсон уу?				
1	Харьяалах ТЭЗ, Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсөл, арга хэмжээ үр дүнтэй эсэхийг тогтоогоогүй байх	дунд	ИХ	ДУНД
2	Концессын зүйлийн үр өгөөжийг төлөвлөх дүрэм, журам, аргачлалыг батлаагүй байх	ИХ	ИХ	ИХ
3	Концессын зүйлийн үр өгөөжийг үнэлээгүй, бодит үр өгөөжийг тооцоогүй байх	дунд	ИХ	ДУНД

- Дунд гэж үнэлсэн "18"
- Их гэж үнэлсэн "9"

Ерөнхий эрсдэлийг "Дунд" гэж үнэлсэн болно

АСУУДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн үү?

1. Концессын зүйл нь холбогдох хууль, эрх зүйн шаардлага хангаж жагсаалтад батлагдаж, концесс эзэмшигчийг хуулийн дагуу сонгон шалгаруулсан уу?

1.1. Концессын зүйл нь холбогдох хууль эрх зүйн шаардлагад нийцж жагсаалтад тусгагдсан уу?

1.1.1. Төсөл, арга хэмжээг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгахдаа хэрэгцээ шаардлага, зардал, ашгийн тооцоололд үндэслэсэн үү?

1.1.2. Концессын болон Төсвийн тухай хуулийн концессын зүйлийн хангасан төсөл, арга хэмжээг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад баталсан уу?

1.2.1. Үрдэчинсан болон урдаантад шалгаруулалтын жишиг баримт бичгийг боловсруулж батлуулсан уу?

1.2.2. Үрдэчинсан болон урдаантад шалгаруулалтыг хуулийн дагуу явуулсан уу?

1.2.3. Харицан үр ашгитай нөхцөлөөр гэрээ байгуулсан уу?

1.2. Концесс эзэмшигч /Гүйцэтгэгч/-ийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдсан уу?

2. Концессын төслүүдийн хэрэгжилт, түүнд тавих хяналт үр дүнтэй хэрэгжиж нийгэмд үр өгөөж бий болсон уу?

2.1. Концессын зүйлийн зураг, төсөв болон барилга угсралтын ажил холбогдох хууль тогтоомж, норм норматив, хэм хэмжээний дагуу хийгдсэн үү?

2.1.1. Барилга, байгууламжийн угсралтын ажлын зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн дагуу төлөвлөгдөж боловсруулагдсан үү?

2.1.2. Барилга угсралтын ажлын төсвийг иж бүрэн, холбогдох норм дүрмийн дагуу тооцсон байна уу?

2.1.3. Концесс эзэмшигч барилга угсралтын ажлыг зураг төслийн дагуу хугацаанд нь бүрэн, чанартай хийж гүйцэтгэсэн үү?

2.1.4. Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг бодит зардалаар тооцож баталгаажуулсан үү?

2.1.5. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комиссоос өрсөн үүрэг даалгавар хэрэгжиж, ашиглалтад байгуулахаас томдол санал гарсан үү?

2.2.1. Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, хариуцлага тооцсон үү?

2.2.2. Захиалагч болон зохиогчийн хяналт үр дүнтэй байна уу?

2.2. Концесс олгогчийн зүгээс тавьж буй хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

2.3.1. Концессын зүйлийг хэрэгжүүлснээр бий болох үр өгөөжийг тооцсон үү?

2.3.2. Концессын зүйлийг хэрэгжүүлснээр тооцоолсон үр өгөөж бий болж төсөл хэрэгжсэн тухайн бүс нутагт нийгмийн ач холбогдлоо өгч байна уу?

2.3. Концессын зүйл хэрэгжсэнээр бий болох хөрөнгө оруулалтын өгөөж, нийгмийн ач холбогдлыг тооцож үнэлсэн үү?



Батлав. Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

Л.Одгэрэл
Л.Одгэрэл
Аудитын хөтөлбөр

Хавсралт №24
УХА0122

Аудитын нэр: Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажил

ID	Үзүүлэлт	Хугацаа	Эхлэх	Дуусах	July							August				September			Ос
					6/18	6/25	7/2	7/9	7/16	7/23	7/30	8/6	8/13	8/20	8/27	9/3	9/10	9/17	
1	Төлөвлөлтийн үе шат	20 days	Fri 6/22/18	Tue 7/17/18	[Redacted]														
2	Урьдчилсан судалгааны хүрээнд ҮХГ, ТЕЗ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, концессын гэрээ, холбогдох тооцоо судалгааг авч төсвийн хуулиудад дүн шинжилгээ хийх	15 days	Fri 6/22/18	Tue 7/10/18	Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ														
3	Концессээр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьсан БХТ холбогдох албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, баримт материалтай танилцах, нотлох баримт цуглуулах	11 days	Thu 6/28/18	Tue 7/10/18	Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ														
4	Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн төслийг боловсруулж газрын удирдлагаар хянуулах	2 days	Mon 7/2/18	Tue 7/3/18	Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ,И.Туяадарь														
5	Төлөвлөгөөний төслийг Ерөнхий аудиторын орлогч даргын хяналтаар оруулах	1 day	Tue 7/3/18	Tue 7/3/18	Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ,И.Туяадарь														
6	Төлөвлөгөөний төслийг Аудитын зөвлөлийн хяналтаар оруулах	2 days	Wed 7/4/18	Thu 7/5/18	Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ,И.Туяадарь														
7	Аудитын зөвлөлийн санал зөвлөмжийг тусган төлөвлөгөөний төслийг Ерөнхий аудиторын орлогчид дахин хянуулах	3 days	Fri 7/6/18	Tue 7/10/18	Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ														
8	Төлөвлөгөөний төслийг Чанарын баталгаажуулалтын албаны хяналтаар оруулах	1 day	Mon 7/16/18	Mon 7/16/18	Ц.Цолмон														
9	Аудитын төлөвлөгөөг Ерөнхий аудиторын хяналтаар оруулж батлуулах	1 day	Tue 7/17/18	Tue 7/17/18	Ц.Цолмон														
10	Талбарт аудитыг гүйцэтгэх	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18															
11	Аудитын багийг холбогдох байгууллагад танилцуулж аудитыг эхлүүлэх	1 day?	Mon 8/6/18	Mon 8/6/18	ГАГ-ын захирал Л.Одгэрэл,Аудитын менежер Б.Саруул,Аудит														
12	СЯ, ҮХГ, холбогдох ТЕЗ, концессын жагсаалтын төлөвлөлт, хэрэгжилтэд тавьж буй хяналт үр нөлөөтэй эсэхэд нотлох баримт цуглуулах	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18															
13	ҮХГ-аас концессын гэрээ байгуулах, сонгон шалгаруулалт явуулах үйл явцыг судалж нотлох баримт цуглуулах	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18	Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ														

Project: ГАГ/2018/03-ГА
Date: 2018.07.16

Үе шатны үргэлжлэх хугацаа [Redacted] Нийт үргэлжлэх хугацаа [Redacted]

Хянасан: Аудитын менежер: *Б.Саруул* Б.Саруул Боловсруулсан: Аудитор *Ц.Цолмон* Ц.Цолмон

Батлав. Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

Л.Одгэрэл


Аудитын хөтөлбөр

Аудитын нэр: Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажил

ID	Үзүүлэлт	Хугацаа	Эхлэх	Дуусах	July							August				September				October	
					6/18	6/25	7/2	7/9	7/16	7/23	7/30	8/6	8/13	8/20	8/27	9/3	9/10	9/17	9/24	10/1	10/8
14	ТАХ-ний концессын зүйлийн жагсаалтад анх тусгуулахад ТЕЗ, ҮХГ, СЯ зэрэг ТБ-даас дээд байгууллагад танилцуулсан танилцуулга, ТЭЗҮ, зардал, ашгийн судалгаа тооцоог гаргуулан авч нотлох баримт цуглуулах	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																
15	Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд хэрэгжсэн 320 суудалтай хүүхдийн сургуулийн барилга	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18	Ц.Цолмон																
16	Хөвсгөл аймгийн Тариалан суманд хэрэгжсэн Соёл, спортын цогцолборын барилга	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18	Ц.Цолмон																
17	Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд хэрэгжсэн 150 ортой цэцэрлэгийн барилга	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18	Б.Хаш-Эрдэнэ																
18	Ховд аймгийн Жаргалант суманд хэрэгжсэн 180 ортой 1 дүгээр цэцэрлэгийн барилга	25 days	Mon 8/6/18	Fri 9/7/18	Б.Хаш-Эрдэнэ																
19	Хөндлөнгийн шинжээч нарын дүгнэлтийг хүлээн авч үе шатны хяналтыг хэрэгжүүлэн дүн шинжилгээ хийж дүгнэлтийн төсөлд нэгтгэх	5 days	Mon 9/3/18	Fri 9/7/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																
20	Тайлагнал	6 days	Mon 9/10/18	Mon 9/17/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																
21	Аудитын зорилт, дэд асуудлаар цуглуулсан материал, шинжээчийн дүгнэлтэд дүн шинжилгээ, боловсруулалт хийх, илэрсэн зөрчил, асуудлыг ГА-ын журмын батлагдсан маягтын дагуу бичиж аудитын менежерийн хяналт хийлгэх	3 days	Mon 9/10/18	Wed 9/12/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																
22	Шалгасан концессын зүйл тус бүрээр шалгагдагч байгууллагатай хаалтын уулзалтыг хийж зөвшилцөх	3 days	Wed 9/12/18	Fri 9/14/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																
23	Тайлангийн үе шатны хяналт, баталгаажуулалт, тайлан хүргүүлэх, архив	19 days	Mon 9/17/18	Wed 10/10/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																
24	Дүгнэлтийн төслийг аудитын менежерээр хянуулах	3 days	Mon 9/17/18	Wed 9/19/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																
25	Дүгнэлтийн төслийг газрын захирлаар хянуулах	3 days	Wed 9/19/18	Fri 9/21/18	Ц.Цолмон, Б.Хаш-Эрдэнэ																


Project: ГАГ/2018/03-ГА
Date: 2018.07.16Үе шатны үргэлжлэх хугацаа  Нийт үргэлжлэх хугацаа 

Хянасан: Аудитын менежер:



Б.Саруул

Боловсруулсан: Аудитор



Ц.Цолмон

Батлав. Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор

Л.Одгэрэл

Аудитын хөтөлбөр

Аудитын нэр: Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажил

ID	Үзүүлэлт	Хугацаа	Эхлэх	Дуусах	July					August				September				October			
					6/18	6/25	7/2	7/9	7/16	7/23	7/30	8/6	8/13	8/20	8/27	9/3	9/10	9/17	9/24	10/1	10/8
26	Дүгнэлтийн төслийг Ерөнхий аудиторын орлогчоор хянуулах	3 days	Fri 9/21/18	Tue 9/25/18																	
27	Холбогдох байгууллагын саналыг тусган дүгнэлтийн төслийг АЗ-өөр хэлэлцүүлж, холбогдох засварыг хийх	2 days	Tue 9/25/18	Wed 9/26/18																	
28	Дүгнэлтийн төслийг ЧБА-аар хянуулах	2 days	Wed 9/26/18	Thu 9/27/18																	
29	Дүгнэлтийн эцсийн төслийг Ерөнхий аудиторт танилцуулж хянуулах	2 days	Thu 9/27/18	Fri 9/28/18																	
30	Дүгнэлтийг эцэслэн баталгаажуулах, хэвлүүлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх	1 day	Mon 10/1/18	Mon 10/1/18																	
31	Аудиттай холбоотой баримт материалыг үдэж цэгцлэн, архивт хүлээлгэн өгөх	7 days	Tue 10/2/18	Wed 10/10/18																	

Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ

Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ


Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ

Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ

Ц.Цолмон,Б.Хаш-Эрдэнэ


Project: ГАГ/2018/03-ГА
Date: 2018.07.16Үе шатны үргэлжлэх хугацаа  Нийт үргэлжлэх хугацаа 

Хянасан: Аудитын менежер:




Б.Саруул

Боловсруулсан: Аудитор



Ц.Цолмон



Дүгнэлт гаргах концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил

№	Концессын зүйлийн нэр	Концессын төрөл	Гэрээний		Концесс эзэмшигчийн нэр	Төсөл, арга хэмжээний байршил	Концесс хэрэгжүүлэх хугацаа		Валютын төрөл	Гэрээний Мөнгөн дүн	
			Огноо	дугаар			Эхлэх	Дуусах		Үндсэн валютаар	Сая нэгжээр
Барих-шилжүүлэх” төрлөөр нийгмийн салбарын барилга байгууламжид гэрээ байгуулсан											
1	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 320 хүүхдийн сургуулийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.22	ХОГ-2016/73/7-46-21	Хөвсгөл геологи ХК	Хөвсгөл аймгийн Цагаан уул сум	2016.06.22	2017.10.01	MNT	6,116,389,381.00	6,116.4
2	Хөвсгөл, Цагаан-Уул сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.22	ХОГ-2016/73/7-46-34	Хөвсгөл геологи ХК		2016.06.22	2017.09.25	MNT	2,806,617,681.00	2,806.6
3	Хөвсгөл, Тариалан сум, Соёл, спортын цогцолборын барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.20	ХОГ-2016/74/7-46-47	Идэр чандмань ХХК	Хөвсгөл аймгийн Тариалан сум	2016.06.20	2017.08.30	MNT	3,616,539,040.00	3,616.5
4	Ховд, Жаргалант, 180 ортой 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих төсөл	Барих-шилжүүлэх	2016.06.24	ХОГ-2016/73/7-46-24	Улаан дөл ХХК	Ховд аймгийн Жаргалант сум	2016.06.24	2017.06.15	MNT	2,050,346,111.00	2,050.3
	Дүн									14,589,892,213.00	14,589.9


Аудитын үр өгөөжийн төлөвлөлт

2018 оны 7 дугаар сарын 17-ны өдөр

Хавсралт №8

Аудитын код: ГАГ-2018-03-ГА Аудитын нэр: “Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт гаргах”	Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орон гүйцэтгэгч Д.Одгэрэл Аудитын менежер Б.Саруул Аудитор Ц.Цолмон
<p>Ерөнхий мэдээлэл: Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах”-аар заасан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан 242 арга хэмжээнээс 2017 оны байдлаар концессын 57 зүйлийн гэрээ байгуулагдсанаас 42 гэрээ нь концессын “барих шилжүүлэх” төрөл байна.</p> <p>2017-2018 оны эхний хагаст улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж дууссан 15 төсөлд дүгнэлт гаргасан бөгөөд нэмж 4 төсөлд дүгнэлт гаргахаар байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумд 320 суудалтай хүүхдийн сургуулийн барилга; ▪ Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумд 150 ортой цэцэрлэгийн барилга; ▪ Хөвсгөл аймгийн Тариалан сумд Соёл, спортын цогцолборын барилга; ▪ Ховд аймгийн Жаргалант сумд 180 ортой 1 дүгээр цэцэрлэгийн барилга; 	
<p>Уламжлалт эрсдэлтэй асуудлууд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Улс орон нутаг, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй ТАХ төлөвлөх, ✓ Техникийн нөхцөл шийдэгдээгүй, ТЭЗҮ зураг төсөвгүй ТАХ-г төлөвлөх, ✓ Уралдаант шалгаруулалтыг хуулийн дагуу явуулаагүй, өрсөлдөөнийг хязгаарласан байх, ✓ Хуурамч гүйцэтгэл гаргаж, төсөвт өртгийг өсгөх, санхүүжилт илүү авах, ✓ Чанаргүй ажил гүйцэтгэж, хөрөнгийн үр ашгийг хангаагүй байх. 	
Онилох үндсэн чиглэл:	- Концессын төслүүдийн зураг төсөл, төсөв болон барилга угсралтын ажил холбогдох хууль тогтоомж, норм норматив, хэм хэмжээний дагуу хийгдсэн эсэх - Төсөл хэрэгжсэнээр бий болох эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж, нийгмийн ач холбогдлыг үнэн зөв тодорхойлсон эсэх.
Хоёрдогч асуудал:	Концессын зүйл нь холбогдох хууль, эрх зүйн шаардлагад нийцэж, концессын зүйлийн жагсаалтад зохих ёсоор тусгагдсан эсэх,
<p>Аудитад гарах нийт зардлын мөнгөн дүн</p> <p>а/ Хүний нөөц: УАГ-аас 2 хүн – 55 хүн/өдөр 6.226.0 мян.төг ГЗ, АМ-ийн хяналт 30 хүн өдөр 2,406.0 мян.төг</p> <p>б/ Бичиг хэрэг 500.0 мян.төг</p> <p>в/ Томиллолт, зам хоног 4 хүн 5-7 хоног 3,536.3 мян.төг,</p> <p>г/ Хөндлөнгийн шинжээч, экспертний зардал нийт .38,000.0 мян.төг, нийт 50.668,3 мянган төг</p> <p>д/ Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, зургийн аппарат, диктафон, бусад</p>	

<p><u>Санхүүгийн үр өгөөж гарч болох эх сурвалж:</u></p> <p>Улсын төсвийн хөрөнгө хэмнэлттэй бус, гэрээний үүргийн биелэлтэд хариуцлага тооцоогүй хөрөнгийн үр ашиг хангалтгүй байх.</p>	<p><u>Үр өгөөжийн тооцоолол:</u></p> <p>Концессын барих шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлж буй нийгмийн салбарын 4 барилгад 14,589.9 сая төгрөгийн концессын гэрээ байгуулагдсан байна.</p> <p>Үүнээс батлагдсан зураг, барилгын норм дүрмийн дагуу гүйцэтгээгүй байх, хуулийн шаардлагад нийцээгүй байх, хяналт хангалтгүйгээс хийгдээгүй ажлын санхүүжилтийг олгосон байх зэрэгт зөрчил байх магадлалтай гэж тооцоход 100.0-500.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж гарна гэж тооцов.</p>				
<p><u>Гарч болох санхүүгийн үр өгөөжийн шатлал (сая төгрөг)</u></p>	0	100 хүртэл	100-500	500-1000	1000 +
<p><u>Чанарын дэвшил, сайжрал бий болгох гол асуудлууд:</u></p> <p><u>Арвилан хэмнэлтийн хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Чанаргүй ажил хийгдэх, илүү санхүүжилт авах эрсдэлийг бууруулах; - Төлөвлөлтийн бодлого, арга аргачлалыг сайжруулах; - Нөөцийн хуваарилалтыг оновчтой болгоход дэмжлэг болох. <p><u>Үр ашгийн хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хэрэгцээ шаардлагагүй, үр ашиггүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх; - ТЭЗҮ, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг төсөвт тусгахгүй байх; - Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх; - Хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлэх; - Хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөжийг тооцдог болох. <p><u>Үр нөлөө үзүүлэх хүрээнд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Хөрөнгө оруулалтын ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлдог болох; - Гэрээний хэрэгжилтийг сайжруулах; - Уралдаант шалгаруулалтыг үр нөлөөтэй зохион байгуулах; - Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцдог байх; - Төлөвлөлт, хяналт, удирдлага, хариуцлага сайжрах. 					



МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫГ ТОДОРХОЙЛОХ МАЯГТ

Материаллаг байдлын суурь үзүүлэлт	Гэрээний дүн	Сонгосон түвшин	Доод түвшин	Дунд түвшин	(сая төгрөг)	
		0.5%	1%	1.5%	Дээд түвшин 2%	
А	Б		1	2	3	
Барих-шилжүүлэх" төрлөөр нийгмийн салбарын барилга байгууламжид байгуулсан гэрээний дүн	14,589.89	72.95	145.9	218.8	291.8	
Засгийн газрын дотоод ерд концессын зүйлийн бүртгэгдсэн өр	750,900.00	3,754.50	7,509.0	11,263.5	15,018.0	

Сонгосон төлөвлөлтийн материаллаг байдал:

Материаллаг байдлын суурийг нийгмийн салбарын барилга байгууламжид гэрээний дүнгийн 0.5 хувиар тооцож тогтоосон болно. Үүнд:

Концессын зүйлийн нэр	Гэрээний			материаллаг түвшинг гэрээний дүнгийн 0.5 хувиар тооцов /сая.төг/
	Валютын төрөл	Мөнгөн дүн		
		Үндсэн валютаар	Сая төгрөгөөр	
Хөвсгөл, Цагаан-Уул сум, 320 хүүхдийн сургуулийн барилга барих төсөл	MNT	6,116,389,381.00	6,116.4	30.6
Хөвсгөл, Цагаан-Уул сум, 150 ортой цэцэрлэгийн барилга барих төсөл	MNT	2,806,617,681.00	2,806.6	14.0
Хөвсгөл, Тариалан сум, Соёл, спортын цогцолборын барилга барих төсөл	MNT	3,616,539,040.00	3,616.5	18.1
Ховд, Жаргалант, 150 ортой 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих төсөл	MNT	2,050,346,111.00	2,050.3	10.3
Дүн			14,589.9	72.9

Хувь хэмжээг сонгосон шалтгаан:

Аудитын явцад илрүүлэлтийн хүлээн зөвшөөрөх алдааны хязгаарыг тооцохын тулд хамгийн бага түвшинг суурь болгон авсан болно.

Чанарын холбогдолтой асуудал:

Төсөл хэрэгжсэнээр нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, төсөвт үзүүлэх ачаалал, арвилан хэмнэлтийг харгалзаж үзнэ.

Бэлтгэсэн: Аудитор

У.Валсан

Ц.Цолмон

БАТЛАВ: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ОЮУНБИЛЭГ

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН АЖЛЫН ДААЛГАВАР №12

2018 оны 6 дугаар сарын 19

Ажлын зорилт: Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа сургууль, цэцэрлэг, соёл, спортын төвийн барилга байгууламжийн зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхойлогдсон зарчим, шаардлага, олон нийт, үйлчлүүлэгчдийн эрх ашиг, шилдэг арга туршлага, бусад хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргах.

Хугацаа: 1.5 сар

Эхлэх хугацаа: 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

Байршил: Улаанбаатар хот, Монгол улс

1. Ерөнхий зүйл

Улсын Их Хурлын 2015 оны 108 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны "Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай" 308 дугаар тогтоолыг үндэслэн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 320 суудалтай сургуулийн барилга барих ХОГ-2016/73/7-46-21 дугаартай концессын "барих-шилжүүлэх" гэрээг 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдөр "Хөвсгөл геологи" ХК-тай байгуулсан байна.

Концессын гэрээний дагуу төслийн нийт хөрөнгө оруулалт 6,116.4 сая төгрөг бөгөөд сургуулийн барилгыг 2017 оны 10 дугаар сарын 01-ний дотор барьж, ашиглалтад оруулахаар заажээ.

Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 29 дүгээр тогтоолын 7 дахь заалтад "улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэл хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах"-аар заасан.

"Хөвсгөл геологи" ХК-ийн барьсан сургуулийн барилга угсралтын ажил дуусаж улсын комисс хүлээн авсан бөгөөд концессын төсөлд дүгнэлт гаргах ажлыг үр дүнтэй, чанартай гүйцэтгэхийн тулд зураг төсөл, төсөв болон гүйцэтгэлийн байдалд хөндлөнгийн мэргэжлийн шинжээчдийг ажиллуулж, дүгнэлт ирүүлэх хуулийн этгээдтэй хамтран ажиллахаар шийдвэрлэсэн бөгөөд ингэхдээ УАГ мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд төсөлд мэргэжлийн, хараат бус, бодитой дүгнэлт гаргах үүргийг гэрээний дагуу хүлээнэ.

2. Ажлын зорилго

Шинжээч нь 2018 оны 07 дугаар сарын 01-ний байдлаар концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжиж дууссан, байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн барилга, байгууламжийн зураг төсөл нь зохих норм, журмын дагуу зохиогдсон эсэх, холбогдох

С.ОЮУНБИЛЭГ

Дэвшил БАНЛЫН АЖИЛЛАГАА

төсөв нь бодитой, үнэн зөв тооцоологдсон эсэх, барилга угсралтын ажил нь холбогдох зураг, төсвийн дагуу чанартай хийгдсэн эсэх, барилгын зураг, төсөл зохиогч болон захиалагчийн хяналт үр дүнтэй хийгдсэн эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмж боловсруулна.

3. Барилга байгууламжийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах ажилбар

Шинжээч нь концессын барих-шилжүүлэх төрлөөр баригдаж, ашиглалтад орсон барилга, байгууламжийн зураг төсөл нь зохих норм, журмын дагуу зохиогдсон эсэх, холбогдох төсөв нь бодитой, үнэн зөв тооцоологдсон эсэх, барилга угсралтын ажил нь холбогдох зураг, төсвийн дагуу чанартай хийгдсэн эсэх талаар мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын хүрээнд дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1 Барилга, байгууламжийн угсралтын ажлын зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангаж, холбогдох төлөвлөлт, судалгаанд үндэслэсэн эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах,
- 3.2 Барилга байгууламжийн ажлын төсөв нь батлагдсан зураг төслийн дагуу холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиогдож, хянагдсан эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.3 Барилга байгууламжийн суурь, бүтээц, угсралтын ажил зураг төсөл, техникийн шаардлагын дагуу хийгдсэн эсэх:
 - төмөр бетоны марк
 - барилгын байгууламжийн суурийн ажил
 - өрлөг, хана, цутгалтын ажил
 - тааз, дээвэр, хучилтын ажил
 - гадна тохижилт, заслын ажлын гүйцэтгэлийг нягталж, дүгнэлт гаргах,
- 3.4 Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний гадна, дотор цахилгааны шугамын угсралтын ажил зураг төслийн дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.5 Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний гадна, дотор дулааны ажил зураг төслийн дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.6 Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний сантехникийн тоноглол угсралтын ажил зураг төслийн дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.7 Барилга байгууламжийн гадна орчны тохижилтын ажил зураг төслийн дагуу хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргах,
- 3.8 Барилга байгууламжийн угсралтын үе шатны ажлуудад захиалагчийн болон техникийн хяналтыг зохих ёсоор гүйцэтгэсэн, өгсөн зааварчилгааг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах,
- 3.9 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан бол тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрхэн хэрэгжсэн эсэхэд дүгнэлт гаргах.
- 3.10 Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийн хувьд батлагдаж, хянагдсан төсөв болон бодит гүйцэтгэл зөрүү илэрсэн бол тэдгээрийн гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг

тогтоож, барилга угсралтын явцад төсөвт гарсан хэмнэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах.

Ажлын хамрах хүрээ:

Шинжээч нь концессын барих-шилжүүлэх төрлөөр хэрэгжсэн дараах барилга, байгууламжид дүгнэлт гаргана.

Хүснэгт 1. Дүгнэлт гаргах концессын зүйлийн жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Концесс эзэмшигч	Валют	Ажил гүйцэтгэх хугацаа		Ажлын гүйцэтгэл хувиар
				Эхлэх	Дуусах	
1	Сургуулийн барилга /Хөвсгөл, Цагаан-Уул сум, 320 суудалтай/	Хөвсгөл геологи ХК	₮	2016.06.22	2017.10.01	100

Эх сурвалж: Үндэсний хөгжлийн газар

4. Хүлээгдэж буй үр дүн

Шинжээч нь концессын барих-шилжүүлэх төрлөөр баригдсан барилга байгууламжийн зураг төсөл, төсөв, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудыг хангасан эсэх, барилга байгууламжууд зураг төсөл, техникийн шаардлагын дагуу баригдсан эсэхийг хянан үзэж, барилга, байгууламж нэг бүрээр шинжээчийн дүгнэлт гаргахын зэрэгцээ, шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагааны үр дүнг тусгасан шинжээчийн тайланг загварын дагуу бичиж ирүүлнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийг учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, санал боловсруулж тусгана.

5. Зохион байгуулалт

Шинжээч нь УАГ-тай гэрээ байгуулж ажиллах ба тус газрын Гүйцэтгэлийн аудитын газарт ажлаа тайлагнаж, шаардлагатай туслалцааг тус газраас үзүүлнэ.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний хөгжлийн газрын Концесс, ТХХТ-ийн албаны ажилтнууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн хуулийн этгээд, гүйцэтгэгч аж ахуйн нэгж зэрэг байгууллагуудаас төсөл, арга хэмжээний зургийн даалгавар, архитектур төлөвлөлтийн даалгавар, зураг төсөл, төсөв зохиохтой холбоотой шаардлагатай баримт материалыг Үндэсний аудитын газрын аудитын баг гаргуулна.

6. Ажил гүйцэтгэх хугацаа

Ажил гүйцэтгэх хугацаа 1.5 сар буюу 2018 оны 7 дугаар сарын 01-нээс 8 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл байна.

7. Төлбөрийн нөхцөл

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээ байгуулагдсаны дараа гэрээт ажлын урьдчилгаа төлбөрт гэрээний үнийн дүнгийн 40 хүртэл хувийг олгох ба үлдэгдэл санхүүжилтийг 2 хувааж олгоно.

Үлдэгдэл санхүүжилтийн эхний хэсэг буюу гэрээний үнийн дүнгийн 55 хүртэл хувийг гэрээт ажлыг Захиалагч тал хянаж, хүлээн авсны дараа олгох бол үлдэгдэл санхүүжилтийн сүүлийн хэсэг болох гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх төлбөрийг хөрөнгө оруулалтын аудитын тайлан бэлтгэгдэж, УИХ болон бусад талуудад хүргүүлсний дараа олгоно.

8. Шинжээчид тавигдах шаардлага

Шинжээч хуулийн этгээд нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл, төсөв боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, эдийн засгийн үр өгөөжийг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай мэргэжилтнүүдийг ажиллуулна. Шинжээчийн баг нь дараах мэргэжил, мэргэшлийн шаардлагыг хангасан мэргэжилтэнтэй байна.


Үүнд:

- Барилга бүтээц, архитектур, угсралт, сантехник, дулаан, цахилгаан хангамж, холбоо дохиоллын чиглэлээр мэргэшсэн зөвлөх инженер;
- Барилга, байгууламжийн төсөвт өртөгт тооцоолол хийх тэргүүлэх эсвэл мэргэшсэн төсөвчин, барилгын зөвлөх эдийн засагч;
- Тухайн мэргэжилтнүүд барилгын салбарт мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан ажлын туршлагатай;
- Барилга, байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийн тооцоололд дүгнэлт гаргах чадвартай, ижил төрлийн ажил гүйцэтгэж байсан туршлагатай байна.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ болон аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Боловсруулсан:


ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АУДИТЫН МЕНЕЖЕР



Б.САРУУЛ

Хянасан:

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ОДГЭРЭЛ

БАТЛАВ: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ОЮУНБИЛЭГ

**ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН АЖЛЫН ДААЛГАВАР №2**

2018 оны 6 дугаар сарын 20

Ажлын зорилт: Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа сургууль, цэцэрлэг, соёл, спортын төвийн барилга байгууламжийн зураг төсөл, төсөв болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомжоор тодорхойлогдсон зарчим, шаардлага, олон нийт, үйлчлүүлэгчдийн эрх ашиг, шилдэг арга туршлага, бусад хэм хэмжээнд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргах.

Хугацаа: 1.5 сар

Эхлэх хугацаа: 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдөр

Байршил: Улаанбаатар хот, Монгол улс

1. Ерөнхий зүйл

Улсын Их Хурлын 2015 оны 108 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны “Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” 308 дугаар тогтоолыг үндэслэн Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих ХОГ-2016/73/7-46-34 дугаартай концессын “барих-шилжүүлэх” гэрээг 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдөр “Хөвсгөл геологи” ХК-тай байгуулсан байна.

Концессын гэрээний дагуу төслийн нийт хөрөнгө оруулалт 2,806.6 сая төгрөг бөгөөд цэцэрлэгийн барилгыг 2017 оны 9 дүгээр сарын 25-ны дотор барьж, ашиглалтад оруулахаар заажээ.

Улсын Их Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 29 дүгээр тогтоолын 7 дахь заалтад “улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах”-аар заасан.

